



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 02

Өмнөдэлгэр сум

**Орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Дөрөвдүгээр хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

Дарга:	Ц.Пүрэвдорж	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Батболд	Иргэний төлөөлөл
Гишүүд:	Н.Мөнхбат	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
	Н.Ганбаатар	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
	Д.Өлзийсайхан	Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Ш.Цолмон	Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны ахлах мэргэжилтэн

Г.Эрдэнэсүвд

Иргэний төлөөлөл

2.Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэн, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн журмын дагуу ажиллаж тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг зөвлөлийн дарга (Ц.Пүрэвдорж)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ